



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 218

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй, засвар хийхэд эдийн засгийн хувьд үр ашиггүй 15 нэрийн нийт 11,456,364.21 (арван нэгэн сая дөрвөн зуун тавин зургаан мянга гурван зуун жаран дөрвөн төгрөг хорин нэгэн мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Ж.Алимаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



- 132001514

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн
18 дугаар тогтоолын хавсралт

**Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмж их нэгж	Тоо хэмж ээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/
1	БМАА-н иж бүрэн трактор	2009	ш	1	2,795,447.70	2,795,447.70
2	ЛДС-3 чиргүүл	1980	ш	2	1,032,000.00	2,064,000.00
3	Тракторын чиргүүл	1990	ш	1	227,080.00	227,080.00
4	Лазер принтер /SAMSUNG/	2012	ш	1	113,410.00	113,410.00
5	Скайнер HP-G2410	2008	ш	1	94,700.00	94,700.00
6	Компьютер /Пентиум thrab 4/	2008	ш	1	650,000.00	650,000.00
7	Компьютер /Dell optiplex 380/	2008	ш	1	759,543.00	759,543.00
8	Зөөврийн компьютер /Acer Aspire v3-571/	2013	ш	1	1,099,000.00	1,099,000.00
9	Хувилагч /Canon IR2016J /	2007	ш	1	1,451,175.00	1,451,175.00
10	Компьютер /Dell optiplex 3050dt/	2013	ш	1	775,108.51	775,108.51
11	Өнгөт принтер/EPSON 1390/	2015	ш	1	700,000.00	700,000.00
12	Ажилтны сандал	2008	ш	1	68,900.00	68,900.00
13	Сандал /шар/	2008	ш	3	45,000.00	135,000.00
14	Сандал	2008	ш	7	19,000.00	133,000.00
15	Санхүүгийн Acolous программ	2007	ш	1	390,000.00	390,000.00
	Нийт дүн			24		11,456,364.21 /арван нэгэн сая дөрвөн зуун тавин зургаан мянга гурван зуун жаран дөрвөн төгрөг хорин нэгэн мөнгө/